



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн 69 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий “Үндэсний зөвлөл”-ийн гишүүн Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны Б.Арвинбаярыг чөлөөлж, Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга С.Бэхбатыг, Монгол банкны Тамгын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Энхтөрийг чөлөөлж, Монгол банкны Тамгын газрын Хуулийн хэлтсийн дарга Г. Эрдэнэбаярыг, Монголын Хөрөнгийн Биржийн дэд захирал Д.Мөнхтүшигийг чөлөөлж, Монголын Хөрөнгийн Биржийн захирал Х.Алтайг, Монголын Банкуудын Холбооны ерөнхийлөгч М.Болдыг чөлөөлж, Монголын Банкуудын Холбооны гүйцэтгэх захирал Б.Найдалааг тус тус томилсугай.
2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Ж.Болормаа/-д даалгасугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН